

“Биологийн хичээлд Мод тарих нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж, турших”
төсөл

Монгол Улсын Их Сургуулийн Экологийн Боловсролын Төвөөс Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” хөтөлбөрийн захиалгаар “Биологийн хичээлд Мод тарих нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж, турших” төслийг 2012 оны 11 сарын 1-ээс 2013 оны 5 сарын 30-ны хооронд хэрэгжүүлэв. Энэхүү төслийн зорилго нь “Мод тарих нэгж хичээлийн хөтөлбөр” боловсруулах, түүнийгээ нийслэлийн гэр хорооллын дунд байрлах, сонгож авсан сургууль дээрээ турших, тухайн сургууль дээр эко сургуулийн 7 алхмыг хэрэгжүүлэх, сургуулийн гадаад, дотоод орчны эко байдлыг сайжруулах, сурагч болон багш нарт экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах зэрэг байв. Төслийг хэрэгжүүлэх сургуулийг сонгохдоо боломжит сургуулиудын захиралуудтай ярилцаж, гадаад, дотоод орчны ерөнхий байдлыг шинжиж, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, биологийн багшийн төслийг хамтран хэрэгжүүлэх идэвх, сонирхол, тухайн сургууль дээр өөр гадны төсөл хэрэгжиж байгаа эсэх зэргийг тандан судласан бөгөөд уг тандалтыг үндэслэн нийслэлийн Чингэлтэй дүүргийн 57-р сургуулийг хамгийн тохиромжтой сургууль гэж сонгон авсан болно.

Төслийг урьдчилан боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

1. Эко сургууль болох 7 алхмыг хэрэгжүүлэх: Эко сургууль хөтөлбөр нь олон улсын хөтөлбөр бөгөөд байгаль орчныг хамгаалах болон амьдрах, сурах орчноо аятай, эрүүл, хүүхдэд болон байгальд ээлтэй байлгахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж, байгальд ээлтэй болохын тулд сургууль 7 алхмыг хийж гүйцэтгэх ёстой. Бид энэхүү төслийн хүрээнд юуны өмнө энэхүү 7 алхам нь юу болох, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай 5-аас дээш ангийн бүх сурагчдад мэдээлэл өгч, эко зөвлөлийн гишүүн болж өөрийн ирээдүйн төлөө идэвхтэй ажиллахыг уриалсан сургалт явууллаа. Үүний дараа сайн дураараа, санаачлагаараа Эко зөвлөлийн

гишүүн болсон сурагчдад нарийн, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, сургуулийн болон анги танхимыхаа гадаад, дотоод орчныг үнэлэхэд туслах зорилго бүхий хоёр дахь удаагийн сургалтыг явуулсан болно. Энэ сургалт, мэдээллийн ажлаас гадна төсөл хэрэгжих явцад Эко зөвлөлийн гишүүд, сургуулийн хамт олонд аргагүйн зөвлөгөө байнга өгч ажиллав. Мөн Эко зөвлөлийн үйл ажиллагааг идэвхтэй, үр дүнтэй байлгах, хүүхдүүдийг чиглүүлэх, үйл ажиллагаа явуулахад нь туршлага олгох зорилгоор, нөгөө талаас оюутнуудыг нийгмийн амьдралд оролцож, сурсан мэдсэнээ зориулах боломж олгох үүднээс “Ногоон давалгаа” клубын гишүүн, МУИС-д байгалийн ухааны чиглэлээр суралцдаг оюутан Ж.Гандолгор, Г.Халиун нарыг ажиллуулав. Энэхүү хоёр оюутан маш сайн ажиллаж, хүүхдүүдийн дунд олон арга хэмжээ зохион байгуулж, Эко зөвлөлийг хойшид бие даан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсийг нь тавьж өгсөн юм. Бидний даалган өгсөн бүх ажлыг цаг хугацаанд нь чанартай, итгэлтэй хийж гүйцэтгэсэн энэхүү оюутнуудтай бид хойшид ч хамтран ажиллахдаа таатай байх болно.

2. Сургуулийн эко стандартыг нэмэгдүүлэх, эко анги тохижуулах, сургуулийн гадаад, дотоод орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. Аливаа сургууль, албан байгууллага байгальд ээлтэй болохын тулд гадаад, дотоод орчиндоо мод, цэцэг тарих, арчлан ургуулах, мөн ус, тог цахилгаан, халаалт хэмнэх арга хэмжээ авах шаардлагатай. Хамгийн гол нь сургуулийн орчин хүүхдүүдэд болон сургуульд ажиллагсдад эрүүл, таатай орчин болох ёстой. Эко сургууль болох 7 алхамд ч энэ томоохон байр суурийг эзлэдэг. Гэвч эко сургууль болох гэж буй ихэнх сургуулиудыг харж байхад орчиндоо үнэлгээ хийгээд, үнэлгээндээ үндэслэн болохгүй дутагдалтай зүйлсээ сайжруулья гэтэл хөрөнгө мөнгөний асуудал гарч ирж, гацах байдалд орох нь элбэг байдаг. Энэ асуудлыг шийдэхэд туслах зорилгоор нэг ангийг сонгон авч эко анги болгох, сургуулийг байгальд ээлтэй, байгалийн нөөцөд хэмнэлттэй үйлдэл хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэсэн юм. Энэ ажлын хүрээнд нэг ангийн хана, таазыг сайн чанарын, хоргүй будгаар будуулж янзлуулан, шалыг нь солиулав. Мөн цонх, хаалганы дулаан алдалтыг багасгаж, ангид хог ялгаж хаях сав, мэдээллийн самбар зэргийг байрлууллаа. Мөн эко зөвлөлийн үнэлгээний дүн, сургуулийн хүсэлтэн дээр тулгуурлан нэгдүгээр давхрын 10 ширхэг модон цонхыг вакум цонхоор сольж, гэрэлгүй харанхуй байсан мұхар, давхар болгоны шатны дээр мэдрэгчтэй гэрэл суурилуулав.

Сургуулийн зүүн болон баруун өмнөх талбайд цэцэрлэгжүүлэлт, гоёл чимэглэлийн 14 зүйлийн 1000 гаруй мод тарьж хаягжуулав. Мод тарих ажилд 7,

8-р ангийн сурагчдыг оролцуулсны дээр шаардлагатай багаж хэрэгслийг сургуульд хүлээлгэн өгсөн юм. Мөн сургуулийн үүдний самбарын хэсэгт навчаараа болон цэцгээрээ гоёдог 20 ширхэг тасалгааны цэцгийг байрлуулж, гадна талбайд 170 м² талбайг зүлэгжүүлэн, 21 м² талбайд мандлын цэцэг тарив.

3. Сурагчдад экологийн боловсрол олгох: Эко сургууль болох 7 алхмыг сургууль болгон өөр өөрийн бололцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагааны хамгийн гол хэсэг нь сурагчдад байгаль орчиндоо ээлтэй байх зарчмуудыг сургах, яагаад байгалиа хайрлах хэрэгтэй болох, үүний тулд одооноос, өөрөөсөө хэрхэн эхлэх зэргийг ойлгуулах явдал юм. Бид энэ ажлын хүрээнд сургуулийн 5-р ангиас дээш бүх ангийнханд зориулж Экологийн ул мөр, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг агуулгыг багтаасан сургалт явуулсан юм. Энэ сургалтаар тухайлбал хүүхэд бүхэн энгийн өдөр тутмын ямар үйлдлийг өөрөө хийж хэвших хэрэгтэйг, мөн бидний хаа сайгүй хаясан хог хэдэн жилийн хугацаанд байгальд задралгүй, хэвтэж байдаг тухай ярьсан нь хүүхдүүдийн сонирхлыг их татав. Мөн мод тарих, арчлах хичээлийг 7, 8-р ангийн хүүхдүүдэд зориулан явуулав. Үүнээс гадна сургуулийн коридорт хог задрах хугацааг харуулсан самбар байрлуулж, “Уул уурхай”, “Цөлжилт” сэдвээр постер хийж, “Уур амьсгалын өөрчлөлт”, “Биологийн олон янз байдал” сэдэвт мэдээллийн эвхмэл хийж тараав.

Бид төсөл хэрэгжихийн өмнө болон төслийн дараа бүх 7-р ангийн сурагчид болон 28 багшаас экологийн мэдлэгийг нь үнэлэх, өдөр тутмын үйлдэлдээ байгальд ээлтэй үйлдэл хэр их хийдгийг нь тандах зорилготой тест авч, үнэлэв. Үнэлгээгээр сурагчдын экологийн мэдлэг 860 онооноос 2948 оноо болж 3,4 дахин нэмэгдсэн бол багш нарын мэдлэг 29%-аар нэмэгдсэн дүн гарав. Тус сургуулийн багш нарын экологийн мэдлэг төслийн өмнө ч харьцангуй сайн байлаа.

4. “Биологийн хичээлд Мод тарих нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж, турших”
Уг хичээлийн хөтөлбөрийг 4 цагийн багтаамжтайгаар “Яагаад мод тарих ёстой вэ”, “Мод, сөөгийг яаж таньдаг юм бол?”, “Мод тарихын өмнө”, “Мод тарья, гэвч яаж?” гэсэн сэдвээр боловсруулж, багшид зориулсан гарын авлага, сурагчдад зориулсан дүрсжүүлсэн богино хэмжээний хичээл хэлбэрээр хийж хэвлүүлэв. Энэ хичээлийг хэрхэн заах талаар болон мод, сөөгийг таних талаар сургуулийн биологийн багшид зөвлөгөө өгч, сургав.

Төслийг амжилттай болоход хамтран ажиллах байгууллагын идэвх, сонирхол маш чухал байна. Ялангуяа сургуулийн бүх хүүхдийг хамруулсан сургалт зохион байгуулах, тарисан модыг арчлах, байнга харж хамгаалах ажлаас төслийн үр дүн ихээхэн шалтгаалдаг болохыг бид туршлагаас харлаа. Бидний үйл ажиллагааг дэмжин, Монголын хүүхдүүдэд оюуны хөрөнгө оруулалт хийсэн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” хөтөлбөрийн хамт олон, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан 57-р сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, биологийн багш нар болон Эко түүчээ эко зөвлөлийнхөнд баярласан талархсанаа илэрхийлж байна.

Хавсралт: Экологийн боловсрол олгох сургалтын материалаас



ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

Экологийн үл мөрөө яаж багасгах вэ?

ХҮН БҮР ХИЧЭЭ!

ТОГОО ХЭМНЭЭ!

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

УСАА ХЭМНЭЭ!

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

Хэрэглээгээ багасгая!
Эргүүлэн ашиглая!
Дахин боловсруулъя!

ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭЭ!

Мод, зүлэг, мандлын цэцэг тарих ажил





Экологийн боловсрол олгох сургалт








Эко зөвлөлийн үйл ажиллагаа












Багшид зориулсан гарын авлага, хүүхдэд зориулсан дүрсжүүлсэн хичээл



Экологийн боловсролын төв

2013 оны 6 сар